

ТӨЛӨӨЛӨГЧИД НЭР ДЭВШҮҮЛЭХ

НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛЛАГАА
2020.8.31-нээс 2020.9.06-ныг дуустал

НЭР ДЭВШҮҮЛСЭН НАМ, ЭВСЛЭЭС НЭР ДЭВШИГЧДИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХҮРГҮҮЛЭХ

*Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
сонгуулийн тухай хуулийн 31.2 дахь хэсэг*

БИЕ ДААН НЭРЭЭ ДЭВШҮҮЛЭГЧ БАРИМТ БИЧГЭЭ ХҮРГҮҮЛЭХ

*Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
сонгуулийн тухай хуулийн 31.3 дахь хэсэг*

1. Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт;
2. Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;
3. Хуулийн 28.4-д заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;
4. Хуулийн 28.3.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа;
5. Хуулийн 28.3.2-т заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;
6. Нэр дэвшигчийн намтар;
7. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
8. Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;
9. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг
10. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

1. Нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл;
2. Сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт;
3. Хуулийн 28.4-т заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;
4. Хуулийн 28.3.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын дээд шүүхийн лавлагаа;
5. Хуулийн 28.3.2-т заасан шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;
6. Нэр дэвшигчийн намтар;
7. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
8. Бие даан нэр дэвшигчийг төлөөлж сонгуулийн төв байгууллагатай харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар;
9. Хуульд заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэрээ дэвшүүлэгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт;
10. Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;
11. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг
12. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

Нэр дэвшүүлэх ажиллагаа дууссанаас хойш 5 хоногт багтаан Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.

2020 оны 9 дүгээр сарын 09-ний дотор